



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн “Итгэлтэй амьдрал” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/001/НА-СТА-ОНӨҮӨҮГ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.16 № 323
танай _____ -ны № _____ -т

ИТГЭЛТЭЙ АМЬДРАЛ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ү.ХАТАНХҮҮ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Итгэлтэй амьдрал ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй үйл ажиллагаа явуулсан, нийт борлуулалтын 96.9 хувийг "Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх" арга хэмжээний санхүүжилтээс бүрдүүлсэн, мөн төрд үзүүлсэн үйлчилгээнд хамааралгүй төлбөр 68,762.7 мянган төгрөгийг нэхэмжилж авсан, 11 төрлийн бараа ажил үйлчилгээ нийлүүлэгчтэй 205,561.8 мянган төгрөгийн гэрээ байгуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт болон НББОУС 1 стандарттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, ангилал, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар архины хамааралтай иргэдийн бүртгэл мэдээллийн системтэй болсон байна.

4626050848

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хамаарал бүхий 307 иргэнд биеийн болон сэтгэл зүйн эмчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын захирамжаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам баталж, захирамжийн хэрэгжилтийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар шалгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	128,361,408.68	140,911,903.46
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	128,361,408.68	140,911,903.46
4	Дансны авлага	1,463,960.45	29,074,647.00
8	Бараа материал	49,372,780.00	67,347,934.34
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	179,198,149.13	237,334,484.80
15	Үндсэн хөрөнгө барилга	115,498,274.89	108,026,647.23
23	Биет бус хөрөнгө	-	17,279,166.67
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	115,498,274.89	125,305,813.90
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	294,696,424.02	362,640,298.70
31	Татварын өр	4,524,978.00	-
38	Бусад богино хугацаат өр төлбөр	13,888,384.76	-
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,413,362.76	-
46	Бусад урт хугацаат өглөг	-	17,279,166.67
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	17,279,166.67
49	Өр төлбөрийн нийт дүн	18,413,362.76	17,279,166.67
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	276,283,061.26	345,361,132.03
61	Эздийн өмчийн дүн	276,283,061.26	345,361,132.03
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	294,696,424.02	362,640,298.70

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	189,087,490.69	668,865,717.90
2	Борлуулалтын өртөг	-	448,958,675.19
3	Нийт ашиг	-	219,907,042.71
8	Бусад орлого	160,246,649.30	37,071,015.33
10	Ерөнхий ба удирдлагын зардал	69,782,928.46	123,509,987.27
11	Санхүүгийн зардал	19,751.47	-
12	Бусад зардал	3,248,398.80	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	276,283,061.26	133,468,070.77
20	Татвар дараах ашиг (алдагдал)	276,283,061.26	133,468,070.77
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	276,283,061.26	133,468,070.77

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	276,283,061.26	276,283,061.26
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	133,468,070.77	133,468,070.77
14	Өмчид гарсан өөрчлөлт	(64,390,000.00)	(64,390,000.00)
17	2025 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	345,361,132.03	345,361,132.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2	Мөнгөн орлогын дүн (+)	200,245,993.12	811,339,572.35
9	Мөнгөн зарлагын дүн (-)	71,864,832.97	798,789,077.57
10	Ажиллагчдад төлсөн	26,436,041.26	308,831,437.54
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	88,888,653.08

12	Бараа материалын худалдан авахад төлсөн	28,900,296.20	215,634,484.73
13	Ашиглалтын зардалд төлсөн	3,906,032.63	21,720,539.68
16	Татварын байгууллагад төлсөн	-	28,471,555.85
18	Бусад мөнгөн зарлага	12,622,462.88	135,242,406.69
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	128,381,160.15	12,550,494.78
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	128,381,160.15	12,550,494.78
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,751.47	128,361,408.68
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,361,408.68	140,911,903.46

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2025 он		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь (+,-)	Дүн (+,-)
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					
	а/Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	1,116,800.0	668,865.7	60%	(447,934.3)
	д/Нутгийн дэм	мян.төг		37,071.0		37,071.0
2	Нийт орлого	мян.төг	1,116,800.0	705,936.7	63%	(410,863.3)
3	Нийт зардал	мян.төг	1,111,508.5	572,468.7	52%	(539,039.9)
3.1	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	129,501.9	123,510.0	95%	(5,991.9)
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	5,291.5	133,468.1	2522%	128,176.6
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	0.0	0.0		0.0
6	Төсвийн төлбөр	мян.төг	99,479.6	121,794.8	122%	22,315.2
6.6	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	88,980.0	88,688.7	100%	(291.3)
68	ХХОАТ	мян.төг	10,499.6	33,106.2	315%	22,606.5
8	Ажиллагсдын тоо	хүн	13.0	10.0	77%	(3.0)
9	Нийт цалингийн сан	мян.төг	800,820.0	364,613.7	46%	(436,206.3)
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	5,133.5	3,038.4	59%	(2,095.0)
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	0.8	81%	(0.2)
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	6,280.0	10,000.0	159%	3,720.0
13	Нийт авлага	мян.төг	0.0	29,074.6		29,074.6
14.2	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	-	17,279.2		17,279.2

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 27,318.9 мянган төгрөгийн НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа илэрснээс аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа:

- Ерөнхий журналаас борлуулалтын орлогыг орлогын дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад 27,318.9 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар нийт 274,324.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 68,762.7 мянган төгрөгийн албан шаардлага, 205,561.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаатай холбоотой, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой, дотоод хяналттай холбоотой зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 274,324.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 267,909.0 мянган төгрөгөөр их боловч шинж чанарын хувьд материаллаг тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

3.2 Албан шаардлага

Өмнөговь аймгийн Засаг даргын 2025 оны А/161 дугаар захирамжийн хэрэгжилтийг тулган шалгахад захирамжийн заалтад хамааралгүй үйлчилгээ үзүүлсэн 32 иргэний 68,762.7 мянган төгрөгийн төлбөрийг төрөөс нэхэмжлэн авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг 7/-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй үйл ажиллагаа явуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулж мөрдөн ажиллах

1.2.Илрүүлэлт: Нийт борлуулалтын орлогын 96,9 хувь буюу 647,989.7 мянган төгрөгийг "Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх" арга хэмжээний санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 3/-д "үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативд хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах", 4/-д "үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйлдвэрийн үйл ажиллагааг хэрхэн нэмэгдүүлж болох талаар судлан хэрэгжүүлж ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: Аж ахуй тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулсан нь нотлогдохгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ, 1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 2/-д "эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ" заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 02 -ний өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөнхий журналаас борлуулалтын орлогыг орлогын дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад 27,318.9 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн	1	27,318.9			1	27,318.9	1	27,318.9				
	Дүн	1	27,318.9			1	27,318.9	1	27,318.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Өмнөговь аймгийн Засаг даргын 2025 оны А/161 дугаар захирамжийн хэрэгжилтийг тулган шалгахад захирамжийн заалтад хамааралгүй үйлчилгээ үзүүлсэн 32 иргэний 68,762.7 мянган төгрөгийн төлбөрийг төрөөс нэхэмжлэн авсан	1	68,762.7			1	68,762.7						
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй үйл ажиллагаа явуулсан	1	0					1	0				
3	Нийт борлуулалтын орлогын 96,9 хувь буюу 647,989.7 мянган төгрөгийг "Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх" арга хэмжээний санхүүжилтээс бүрдүүлсэн	1	0					1	0				

4	Аж ахуй тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулсан нь нотлогдохгүй байна	1	0				1	0				
	Дүн	4	68,762.7			1	68,762.7	3	0			
Худалдан авах ажиллагааны хэрэгжилт												
1	Тайлант онд 11 бараа ажил үйлчилгээ нийлүүлэгчтэй 205,561.8 мянган төгрөгийг гэрээ байгуулаагүй зарцуулсан	1	205,561.8				1	205,561.8				
	НИЙТ ЗӨРЧЛИЙН ДҮН	5	274,324.5			1	68,762.7	4	205.561.8			

